



МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА САНДАГИЙН  
БЯМБАЦОГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.04.20 № ЗГ-1/32

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуудал зөвшилцөх тухай

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264001253

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

**"5.ХЭЛЭЛЦСЭН нь:** Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн тухай

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэн дэмжээд, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## ТАНИЛЦУУЛГА

*Үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг  
ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн талаар  
Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах тухай*

Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлыг үе шаттайгаар, олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхээр талууд тохиролцсон. Мөн 2019 онд байгуулсан “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ”-нд талууд өөрийн нутаг дэвсгэрт байрлах хөрөнгийн хувьд бие биеийн хууль ёсны эрх болон ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, хангана гэж заасан байдаг.

Үүний дагуу Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн эрхийг шинэчлэн бүртгэх ажлын 1 дүгээр үе шатыг хоёр улсын эрх бүхий төлөөлөгчид оролцсон хамтарсан ажлын хэсэг (*Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийг зохицуулах ажлын хэсгийг 1997 оноос хойш нийт 6 удаа байгуулж байсан бөгөөд одоогийн ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 91 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулж, ажлын хэсгийн даргаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга ажиллаж байна*) хоёр улсын Засгийн газар хоорондын 1971, 1979 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын ноот бичгийг солилцож, түүнийг соёрхон батлах тухай хуулийг 2019 онд батлуулсан.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн дагуу ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх, түүний доорх газрын ашиглах эрхийг шинэчлэн бүртгүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгосон ба ОХУ-ын талаас орон сууцны 8 барилгыг Монгол Улсын төрийн өмчид үнэ төлбөргүй хүлээлгэн өгч, тэдгээр байранд 1990 оноос эхлэн амьдарч байсан нийт 550 гаруй өрхөд хувьчилсан.

Ажлын хэсгийн удаах хамтарсан ажил, судалгааны үр дүнд Улаанбаатар, Чойбалсан, Эрдэнэт хотуудад байрлах 8 газар, 93 үл хөдлөх хөрөнгийн объектыг ЗСБНХУ-ын нэр дээрээс ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Энэ хүрээнд талууд эдгээр үл хөдлөх хөрөнгийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийг тусгасан “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг боловсруулан, эцэслээд байна.

Энэ удаагийн хэлэлцээрийн төсөлд дараах үл хөдлөх хөрөнгө хамрагдаж байна:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт байрлах Аэрофлотын барилга (хэсэг), эдэлбэр газрыг ашиглах эрх (Улаанбаатар хот дахь Аэрофлот, АПН, Совэкспорт-Фильмын төлөөлөгчдийн газар зориулан барилга барихад газар олгох болон уг барилгыг барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрт хамаарах);

2. Дорнод аймгийн Хэрлэн сумын төвд байрлах Захиргаа аж ахуйн барилгын цогцолбор (дипломат статустай, Консулын газар ажиллаж байгаад үйл ажиллагаа явуулахаа больсон), эдэлбэр газрыг ашиглах эрх;
3. Орхон аймгийн төвд байрлах Албан контор, орон сууц, аж ахуйн барилгын цогцолбор, эдэлбэр газрыг ашиглах эрх; (дипломат статустай, Консулын газар ажиллаж байгаад үйл ажиллагаа явуулахаа больсон);
4. Нийслэлийн Баянгол дүүрэгт байрлах орон сууцны 56 байр (нийтийн орон сууцны доторх);
5. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах Худалдааны төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн цогцолбор, эдэлбэр газрыг ашиглах эрх;
6. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах Сүмийн барилга, спорт заал, гаражийн цогцолбор, эдэлбэр газрыг ашиглах эрх;
7. Плехановын нэрэмжит сургуулийн барилгын цогцолбор, эдэлбэр газрыг ашиглах эрх.

Тус жагсаалтад байгаа эдэлбэр газрын болон үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг Газрын харилцаа, геодези зураг зүйн ерөнхий газар, нийслэл, аймгийн газрын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээлэлтэй тулган нягталж, эзэмшил, өмчлөлийн маргаангүй болохыг тодруулсан болно.

ОХУ-ын өмчийн үл хөдлөх хөрөнгөд хамаарах эдгээр газрыг үнэ төлбөргүй, хугацаагүй олгосон байсныг өөрчилж, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу газар ашиглах эрхийг 99 жилийн хугацаатай олгож, зохих татварыг төлөхөөр тусгаж хавсралт жагсаалтаар нийт 8 нэгж талбарын 9.57 га газрыг ашиглуулах, 93 нэгж үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулахаар тусгасан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.3 дахь хэсгийн дагуу энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээрийг УИХ-аар заавал соёрхон батлуулах шаардлагатай.

Дээрх дурдсан Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурахад шаардлагатай дотоодын холбогдох журмыг хангаж өгөхийг Монголын талын Ажлын хэсгээс буюу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хүссэний дагуу ийнхүү холбогдох бэлтгэлийг хангаж байна.

Иймд, “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон болно.

--- о О о ---

**“МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ЭДЭЛБЭР ГАЗАР БОЛОН ТЭДГЭЭР БАЙРЛАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ОБЪЕКТУУДЫН ЭРХИЙГ ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН НЭР ДЭЭР ШИНЭЧЛЭН БҮРТГЭХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААР**

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийг 1971-1980 оны хооронд байгуулсан хоёр улсын Засгийн газар хоорондын баримт бичгийн дагуу зохицуулдаг бөгөөд ингэхдээ эдгээр баримт бичигт *“хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулж, тэдгээрт дурдсан барилга байгууламж барихад зориулж газрыг үнэ төлбөргүйгээр, хугацаагүйгээр олгож, газар болон барилга байгууламжийг бүх төрлийн татвар хураамжаас чөлөөлнө”* гэж туссан байдаг. Энэ заалт нь Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байсан тул ОХУ-ын нэр дээр зарим байршилд газар ашиглах гэрчилгээ олгоогүй, кадастрын зураг хийгдээгүй байсан.

Улмаар Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлыг үе шаттайгаар, олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэж, асуудлыг шийдвэрлэхээр талууд тохиролцсон. Мөн 2019 онд байгуулсан “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ”-нд талууд өөрийн нутаг дэвсгэрт байрлах хөрөнгийн хувьд бие биеийн хууль ёсны эрх болон ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, хангана гэж заасан байдаг.

**1. ӨМНӨ ХИЙГДСЭН АЖИЛ БА ЭНЭ УДААГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БУЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ТАЛААР.**

Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн эрхийг шинэчлэн бүртгэх ажлын 1 дүгээр үе шатыг хоёр улсын эрх бүхий төлөөлөгчид оролцсон хамтарсан ажлын хэсэг (*Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийг зохицуулах ажлын хэсгийг 1997 оноос хойш нийт 6 удаа байгуулж байсан бөгөөд одоогийн ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 91 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулж, ажлын хэсгийн даргаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга ажиллаж байна*) хоёр улсын Засгийн газар хоорондын 1971, 1979 оны хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын ноот бичгийг солилцож, түүнийг соёрхон батлах тухай хуулийг 2019 онд батлуулсан.

Хамтарсан ажлын хэсгийн хүрээнд талууд дараагийн шатны зарим үл хөдлөх хөрөнгийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч, энэ нөхцөлийг тусгасан *“Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”*-ийн төслийг боловсруулан, эцэслээд байна.

Монгол Улс дахь Оросын үл хөдлөх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх болон тэдгээрийн эдэлбэр газрыг ашиглах эрхийг ЗСБНХУ нэр дээрх бүртгэлээс ОХУ-ын нэр

дээр үе шаттай шинэчлэн бүртгэх ажлын 2 дугаар үе шатанд талуудын шинжээчдийн ажлын хэсэг Улаанбаатар хот, Орхон, Дорнод аймагт ажиллаж, газрын баталгаажилтын асуудлыг шийдвэрлэх, шаардагдах баримт материалыг бүрдүүлэх, үл хөдлөх хөрөнгийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний тооллого, техникийн баримт бичгийг бүрдүүлэх, үл хөдлөх хөрөнгийн доорх газрын кадастрын зургийг бэлтгэн гаргах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн тэдгээрийн эрхийг шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулан шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцоод байна. Энэ удаад Улаанбаатар, Чойбалсан, Эрдэнэт хотуудад байрлах 8 газар, 93 үл хөдлөх хөрөнгийн объектыг ЗСБНХУ-ын нэр дээрээс ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай гэж үзсэн. Үүнд дараах үл хөдлөх хөрөнгийн объектууд багтаж байна:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт байрлах Аэрофлотын барилга (хэсэг), эдэлбэр газрын ашиглах эрх (Улаанбаатар хот дахь Аэрофлот, АПН, Совэкспорт-Фильмын төлөөлөгчдийн газар зориулан барилга барихад газар олгох болон уг барилгыг барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрт хамаарах);

2. Дорнод аймгийн Хэрлэн сумын төвд байрлах Захиргаа аж ахуйн барилгын цогцолбор (дипломат статустай, Консулын газар ажиллаж байгаад үйл ажиллагаа явуулахаа больсон), эдэлбэр газрын ашиглах эрх;

3. Орхон аймгийн төвд байрлах Албан контор орон сууц, аж ахуйн барилгын цогцолбор, эдэлбэр газрын ашиглах эрх; (дипломат статустай, Консулын газар ажиллаж байгаад үйл ажиллагаа явуулахаа больсон);

4. Нийслэлийн Баянгол дүүрэгт байрлах 56 орон сууцны байр (нийтийн орон сууцны доторх);

5. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах Худалдааны төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн цогцолбор, эдэлбэр газрын ашиглах эрх;

6. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах Сүмийн барилга, спорт заал, гаражийн цогцолбор, эдэлбэр газрын ашиглах эрх;

7. Плехановын нэрэмжит сургуулийн барилгын цогцолбор, эдэлбэр газрын ашиглах эрх.

ОХУ-ын өмчийн үл хөдлөх хөрөнгөд хамаарах газрыг үнэ төлбөргүй, хугацаагүй олгосон байсныг өөрчилж Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу газар ашиглах эрхийг 99 жилийн хугацаатай олгож, зохих татварыг төлөхөөр тусгаж хавсралт жагсаалтаар нийт 8 нэгж талбарын 9.57 га газрыг ашиглуулах, 93 нэгж үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулахаар тусгасан.

Жагсаалтад байгаа эдэлбэр газрын болон, үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг Газрын харилцаа, геодези зураг зүйн ерөнхий газар, нийслэл, аймгийн газрын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээлэлтэй тулган нягталж, эзэмшил, өмчлөлийн маргаангүй болохыг тодруулсан болно.

## **2. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ**

Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн эрхийг бүртгэх ажлын 1 дүгээр үе шатны ажлын хүрээнд ОХУ-ын талтай хамтран ажиллаж, Засгийн газар хоорондын 1971, 1979 оны хэлэлцээр нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын ноот бичгийг соёрхон батлах тухай хуулийг 2019 онд батлуулсан. Энэ хуулийн дагуу ЗСБНХУ-ын өмчлөлд байсан үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх, түүний доорх газрын ашиглах эрхийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгож, мөн ОХУ-ын талаас орон сууцны 8 барилгыг Монгол Улсын төрийн өмчид үнэ төлбөргүй хүлээн авч, тэдгээр байранд 1990 оноос эхлэн амьдарч байсан нийт 550 гаруй өрхөд хувьчилсан нь чухал ач холбогдолтой байсан.

Мөн одоогийн хэлэлцээрийн төслийн хавсралтад багтсан үл хөдлөх хөрөнгийг ОХУ өөрийн нэр дээр шилжүүлээгүйн улмаас захиран зарцуулах эрхгүй байсаар ирсэн. Тэгвэл хэлэлцээрийг байгуулснаар ОХУ өөрийн нэр дээр албан ёсоор шинэчлэн бүртгүүлэх эрх зүйн үндэс нь бүрдэж, тэдгээр үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй болохоос гадна, ямар ч ашиглалтгүй тэдгээр объектууд Монгол Улсын эдийн засгийн эргэлтэд орох боломжтой болно.

Түүнчлэн, Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлыг үе шаттайгаар, олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэж, асуудлыг шийдвэрлэхээр талууд тохиролцсон. Мөн 2019 онд байгуулсан “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ”-нд талууд өөрийн нутаг дэвсгэрт байрлах хөрөнгийн хувьд бие биеийн хууль ёсны эрх болон ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, хангана гэж заасан байдаг.

ЗСБНХУ-ын нэр дээр байсан үл хөдлөх хөрөнгийн ашиглах эрхийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх Засгийн газар хоорондын хэлэлцээрийн зорилго нь хоёр талын харилцааны дээр дурдсан баримт бичгүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд орших ба энэ нь найрсаг харилцаатай, эрчим хүчний чухал түнш ОХУ-тай хоёр талын харилцааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ЭДЭЛБЭР ГАЗАР БОЛОН ТЭДГЭЭРТ  
БАЙРЛАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ОБЪЕКТУУДЫН ЭРХИЙГ ОРОСЫН  
ХОЛБООНЫ УЛСЫН НЭР ДЭЭР ШИНЭЧЛЭН БҮРТГЭХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар цаашид Талууд гэх,

сайн хөршийн харилцаа, нийгэм-эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эрмэлзлийн үүднээс,

Монгол Улс дахь Оросын Холбооны Улсын үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх болон тэдгээрийн эдэлбэр газрыг ашиглах эрхийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр үе шаттай шинэчлэн бүртгэхэд хүчин чармайлт гаргаж,

дараах зүйлийг тохиролцов. Үүнд:

**1 дүгээр зүйл**

1. Оросын тал энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр хавсралтад заасан Оросын Холбооны Улсын өмч болох үл хөдлөх хөрөнгийг эзэмших эрх болон Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсад олгосон Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах эдэлбэр газрыг ашиглах эрхээ Талууд тус бүрийн хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

2. Монголын тал энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад заасан эдэлбэр газар, тэдгээрт байрлаж буй Оросын Холбооны Улсын өмчийн үл хөдлөх хөрөнгийн объекттой холбоотой эрхийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэнэ. Монголын тал эдгээр газрыг холбогдох ашиглалтын гэрээнд заасан нөхцөлийн дагуу оросын талд 99 жилийн хугацаанд ашиглуулахаар шилжүүлж өгнө.

3. Холбогдох эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг Талууд 99 жилийн хугацаа дуусахаас хоёр жилийн өмнө хэлэлцээ хийх замаар тодорхойлно.

4. Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад заасан Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр эрхийг нь шинэчлэн бүртгэвэл зохих Монгол Улсын нутаг дэвсгэрт орших эдэлбэр газар болон тэдгээрт байрлах Оросын үл хөдлөх хөрөнгийн объектуудын жагсаалт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

5. Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт дурдсан эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгөд Монгол Улсын хуулийн этгээдэд ногдуулдгийн нэгэн адил зохих татвар, хураамжийг Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу ногдуулна.

## 2 дугаар зүйл

Улаанбаатар хот дахь Аэрофлот, АПН, Совэкспортфильмын төлөөлөгчийн газрын барилгыг барихад газар олгох болон уг барилгыг барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрт дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулна (цаашид - 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн Хэлэлцээр гэх):

1) 1 дүгээр зүйлд:

"а" хэсгийг дараах байдлаар найруулах:

"а) Монголын тал энэхүү хэлэлцээрийн хавсралтад заасан эдэлбэр газар, тэдгээрт байрлаж буй Оросын Холбооны Улсын өмчийн үл хөдлөх хөрөнгийн объекттой (цаашид "Байшин" гэх) холбоотой эрхийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэнэ. Монголын тал эдгээр газрыг оросын талд холбогдох ашиглалтын гэрээнд заасан нөхцөлийн дагуу 99 жилийн хугацаанд ашиглуулахаар шилжүүлж өгнө.

Холбогдох эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг Талууд 99 жилийн хугацаа дуусахаас хоёр жилийн өмнө хэлэлцээ хийх замаар тодорхойлно.

Энэхүү хэлэлцээрт хавсаргасан Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр эрхийг нь шилжүүлэн бүртгэвэл зохих Монгол Улсын нутаг дэвсгэрт орших эдэлбэр газар болон тэдгээрт байрлах "Байшин"-гийн талаарх мэдээлэл бүхий жагсаалт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.";

"в" хэсгийг дараах байдлаар найруулах:

"в) Энэ зүйлийн (а) хэсэгт заасан эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгөд Монгол Улсын татвар төлөгчид ногдуулдгийн нэгэн адил зохих татвар, хураамжийг Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу ногдуулна.";

2) 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн Хэлэлцээрийн хавсралтыг энэхүү Хэлэлцээрийн хоёрдугаар хавсралтын дагуу өөрчлөх.

## 3 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан газар ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх үүднээс Талуудын эрх бүхий төлөөлөгчид хамтарсан актад тусган гарын үсэг зурсан өдрөөс хойш энэхүү Хэлэлцээрийн 1 болон 2 дугаар хавсралтад заасан эдэлбэр газарт энэхүү Хэлэлцээр, тэр дундаа татвар ногдуулах зохицуулалт хэрэгжинэ.

#### **4 дүгээр зүйл**

Хэрэв Талууд тусдаа хэлэлцээрээр зохицуулаагүй бол энэхүү Хэлэлцээрийн 1 болон 2 дугаар хавсралтад заасан эдэлбэр газарт байрлах барилга, байгууламжийг засварлах, сэргээн босгох, шинээр барилга байгууламж барих болон эдэлбэр газрын тохижуулалтын ажлыг оросын тал Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд өөрийн зардлаар бие даан гүйцэтгэнэ.

Энэ зүйлийн эхний догол мөрөнд заасан оросын талын барьсан шинэ барилга байгууламж нь Оросын Холбооны Улсын өмч байна.

Энэ зүйлийн хоёр дахь догол мөрөнд заасан Оросын Холбооны Улсын өмчийн эрхийн бүрдүүлэлт, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг оросын тал Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

#### **5 дугаар зүйл**

Талууд бичгээр тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрийн зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

#### **6 дугаар зүйл**

Энэхүү хэлэлцээрийг хэрэглэх болон тайлбарлахад үүссэн Талуудын саналын зөрүүг Талууд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

#### **7 дугаар зүйл**

Энэхүү хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хуулийн шаардлагыг биелүүлсэн тухай бичгээр үйлдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

#### **8 дугаар зүйл**

Оросын тал шаардлагатай баримт бичгийг шилжүүлсэн нөхцөлд тус Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн дотор монголын тал энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйл, 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан эдэлбэр газрын эрхийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэнэ.

#### **9 дүгээр зүйл**

Энэхүү Хэлэлцээрийг Талууд зөвхөн бичгээр харилцан зөвшөөрсний дагуу дуусгавар болгож болно. Энэ тохиолдолд Талууд ийнхүү зөвшөөрч буй тухай

дипломат ноот бичиг солилцсон өдрөөс хойш 180 хоногийн дараа энэхүү Хэлэлцээрийн үйлчлэл дуусгавар болно.

Энэхүү хэлэлцээрийн үйлчлэл дуусгавар болсон тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн 1 болон 2 дугаар хавсралтад заасан Оросын Холбооны Улсын эдэлбэр газрыг ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн эрх, мөн түүнчлэн энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан шинэ барилга байгууламжийн өмчлөлийн эрх нь шинэ хэлэлцээр байгуулах хүртэл бүрэн хадгалагдана.

..... хотноо ..... оны .... сарын ....-ны өдөр монгол, орос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн Хавсралт 1

Оросын Холбооны Улсын нэр дээр бүртгэвэл зохих эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын жагсаалт

Д/д	Д/д	Д/д	Эдэлбэр газрын кадастрын дугаар	Хамрах газрын хэмжээ (га)	Үл хөдлөх хөрөнгийн объект	Үл хөдлөх хөрөнгийн нийт ашигтай талбай кв. М	Давхар	Хаяг
1.	1	1	1330800940	2.3351	Албаны барилга	1557.00	2	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг
	2	2			Худалдаа, офисын барилга	542.20	1	
	3	3			Барилга	386.10	1	
	4	4			Клуб	1243.30	1	
	5	5			Барилга	1137.55	2	
	6	6			Амины орон сууц	3342.10	12	
	7	7			Амины орон сууц	701.20	2	
	8	8			Амины бус барилга	28.00	1	
	9	9			Хүлэмж	62.50	1	
	10	10			Агуулах	108.20	1	
2.	11	1	1330801043	0.8294	Барилга	664.65	2	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг
	12	2			18 автомашины гараж-зогсоол	559.47	1	
	13	3			Барилга (Сүм)	265.33	2	
	14	4			Спорт залны барилга	516.81	1	

3.	15	1	1330600455	0.5925	Амины орон сууц	3383.70	Улаанбаатар хот	Баянзүрх дүүрэг
	16	2				422.30		
	17	3				235.70		
4.	18	1	1330800933	2.0950	Төв корпус	4224.70	Улаанбаатар хот	Баянзүрх дүүрэг
	19	2			Бассейн	1043.66		
	20	3			Холбох гарцтай корпус	3778.45		
	21	4			Ангар	238.37		
	22	5			Спортзал	817.75		
	23	6			Аж ахуйн корпус	768.11		
	24	7			Хүүхдийн цэцэрлэг	268.09		
	25	8			Дизелийн станц	77.82		
	26	9			Хүлээн авах	48.80		
	27	1			1330700447	0.1080		
6.	28	1			Орон сууц № 1	48.70	Улаанбаатар хот	Баянгол дүүрэг
	29	2			Орон сууц № 2	68.60		
	30	3			Орон сууц № 3	35.50		
	31	4			Орон сууц № 4	67.30		
	32	5			Орон сууц № 5	48.70		
	33	6			Орон сууц № 6	55.20		
	34	7			Орон сууц № 7	47.50		
	35	8			Орон сууц № 8	67.40		
	36	9			Орон сууц № 9	48.70		
	37	10			Орон сууц № 10	55.20		

38	11	Орон сууц № 11	47.50	-
39	12	Орон сууц № 12	67.40	-
40	13	Орон сууц № 13	48.70	-
41	14	Орон сууц № 14	55.20	-
42	15	Орон сууц № 15	47.50	-
43	16	Орон сууц № 16	67.40	-
44	17	Орон сууц № 17	48.70	-
45	18	Орон сууц № 18	55.20	-
46	19	Орон сууц № 19	47.50	-
47	20	Орон сууц № 20	67.40	-
48	21	Орон сууц № 21	48.70	-
49	22	Орон сууц № 22	55.20	-
50	23	Орон сууц № 23	47.50	-
51	24	Орон сууц № 24	67.40	-
52	25	Орон сууц № 25	48.70	-
53	26	Орон сууц № 26	55.20	-
54	27	Орон сууц № 27	47.50	-
55	28	Орон сууц № 28	67.40	-
56	29	Орон сууц № 29	48.70	-
57	30	Орон сууц № 30	55.20	-
58	31	Орон сууц № 31	47.50	-
59	32	Орон сууц № 32	67.40	-
60	33	Орон сууц № 33	48.70	-


61	34	Орон сууц № 34	55.20	-
62	35	Орон сууц № 35	47.50	-
63	36	Орон сууц № 36	67.40	-
64	37	Орон сууц № 37	67.40	-
65	38	Орон сууц № 38	47.50	-
66	39	Орон сууц № 39	55.20	-
67	40	Орон сууц № 40	48.70	-
68	41	Орон сууц № 57	67.40	-
69	42	Орон сууц № 58	47.50	-
70	43	Орон сууц № 59	55.20	-
71	44	Орон сууц № 60	48.70	-
72	45	Орон сууц № 61	67.40	-
73	46	Орон сууц № 62	47.50	-
74	47	Орон сууц № 63	55.20	-
75	48	Орон сууц № 64	48.70	-
76	49	Орон сууц № 65	67.40	-
77	50	Орон сууц № 66	47.50	-
78	51	Орон сууц № 67	55.20	-
79	52	Орон сууц № 68	48.70	-
80	53	Орон сууц № 69	67.40	-
81	54	Орон сууц № 70	47.50	-
82	55	Орон сууц № 71	55.20	-

	83	56				Орон сууц № 72	48.70	-		
7.	84	1	1460100133	0.3497	Барилгын хэсэг (№ 1 болон № 2 барилгын 3 дугаар орцны 1 давхар болон доорх гараж);		1332.81	3	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг
					Барилгын хэсэг (№ 3 болон № 4 барилгын 2 дугаар орцны 2 болон 3 давхар болон доорх гараж)					
8.	85	1		1.4995	Захиргааны барилга		1155.10	2	Чойбалсан хот	Дорнод аймаг, Хэрлэн сум
	86	2	2106000587		Орон сууцны барилга		524.60	2		
	87	3			Аж ахуйн барилга		75.90	1		
9.	88	1		1.7609	Албаны барилга		2355.30	2	Орхон аймаг	Баян-Өндөр сум
	89	2			Орон сууцны барилга		778.08	3		
	90	3			Гараж болон аж ахуйн корпус		269.30	1		
	91	4	6103300268		Шатахуун түгээх станц		24.00	1		
	92	5			Шуудан болон хамгаалалтын барилга		14.04	1		
	93	6			Гаднах хашлага		1365.90	-		

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн Хавсралт 2

"Улаанбаатар хот дахь Аэрофлот, АПН, Совэкспортфильмын төлөөлөгчдийн газарт зориулан барилга барихад газар олгох болон уг барилгыг барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1980 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээр"-ийн Хавсралт (Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хувилбар)

Эдэлбэр газрын байршлын кадастрын зураг



Нэгж талбарын дугаар: 1460100133

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж. Кадастрын муж: 100"

**СОГЛАШЕНИЕ**  
**между Правительством Российской Федерации и Правительством Монголии**  
**об условиях переоформления прав Российской Федерации**  
**на земельные участки и расположенные на них объекты недвижимости на**  
**территории Монголии**

Правительство Российской Федерации и Правительство Монголии, далее именуемые Сторонами,

исходя из стремления развивать добрососедские отношения и социально-экономическое сотрудничество,

прилагая усилия к урегулированию вопросов, связанных с недвижимым имуществом Российской Федерации в Монголии, а также с поэтапным переоформлением на Российскую Федерацию прав пользования земельными участками,

согласились о нижеследующем:

Статья 1

1. Российская Сторона в отношении объектов недвижимости, являющихся собственностью Российской Федерации, и земельных участков, расположенных на территории Монголии, перечень которых приведен в приложении № 1, осуществляет право собственности на эти объекты недвижимости и право пользования этими земельными участками с учетом законодательства государства каждой из Сторон и норм международного права.

2. Монгольская Сторона обеспечивает переоформление прав на Российскую Федерацию на земельные участки с существующими на них и являющимися собственностью Российской Федерации объектами недвижимости, предусмотренными приложением № 1 к настоящему Соглашению. Монгольская Сторона передает Российской Стороне эти земельные участки в пользование на условиях, определенных в соответствующих договорах пользования, сроком на 99 лет.

3. Условия дальнейшего использования соответствующих земельных участков будут определены путем переговоров Сторон, к которым Стороны приступят за 2 года до истечения 99-летнего срока.

4. Перечень земельных участков, находящихся на территории Монголии, права на которые подлежат переоформлению на Российскую Федерацию, и расположенных на них российских объектов недвижимости, который приведен в

приложении № 1 к настоящему Соглашению, является неотъемлемой частью настоящего Соглашения.

5. Земельные участки, указанные в пункте 1 настоящей статьи, и находящиеся на них объекты недвижимости облагаются налогами и сборами, аналогичными налогам и сборам, предусмотренным действующим законодательством Монголии для монгольских юридических лиц.

## Статья 2

Внести следующие изменения в Соглашение между Правительством Союза Советских Социалистических Республик и Правительством Монгольской Народной Республики о выделении земельного участка для строительства здания представительств Аэрофлота, АПН и Совэкспортфильма в г. Улан-Баторе и об условиях строительства

от 6 августа 1980 года (далее – Соглашение от 6 августа 1980 года):

1) в статье 1:

пункт «а» изложить в следующей редакции:

«а) Монгольская Сторона обеспечивает переоформление прав на Российскую Федерацию на земельный участок с существующим на нем и являющимся собственностью Российской Федерации объектом недвижимости (далее – «Дом») согласно приложению к настоящему Соглашению. Монгольская Сторона передает Российской Стороне указанный земельный участок в пользование на условиях, определенных в соответствующем договоре пользования, сроком на 99 лет.

Условия дальнейшего использования земельного участка будут определены путем переговоров Сторон, к которым Стороны приступят за 2 года до истечения 99-летнего срока.

В приложении к настоящему Соглашению, которое является его неотъемлемой частью, приведен перечень, содержащий сведения о земельном участке, находящемся на территории Монголии, право на который подлежит переоформлению, и расположенном на нем «Доме.»;

пункт «в» изложить в следующей редакции:

«в) Земельный участок, указанный в пункте «а» настоящей статьи, и находящиеся на нем объекты недвижимости облагаются налогами и сборами, аналогичными налогам и сборам, предусмотренным действующим законодательством Монголии для монгольских юридических лиц.»;

2) приложение к Соглашению от 6 августа 1980 года изложить в редакции согласно приложению № 2 к настоящему Соглашению.

### Статья 3

Настоящее Соглашение, в том числе налогообложение, применяется к земельным участкам, указанным в приложениях № 1 и 2 к настоящему Соглашению, и находящимся на них объектам недвижимости с даты подписания совместных актов уполномоченными представителями Сторон во исполнение договоров пользования соответствующих земельных участков, указанных в статье 1 настоящего Соглашения и статье 1 Соглашения от 6 августа 1980 года.

### Статья 4

Ремонт или реконструкция зданий и сооружений, расположенных на земельных участках, указанных в приложениях № 1 и 2 к настоящему Соглашению, строительство новых зданий и сооружений, а также благоустройство земельных участков осуществляются Российской Стороной самостоятельно и за свой счет в соответствии с законодательством Монголии, если иное не предусмотрено отдельным соглашением Сторон.

Новые здания и сооружения, указанные в абзаце первом настоящей статьи, построенные Российской Стороной, являются собственностью Российской Федерации.

Юридическое оформление и государственная регистрация права собственности Российской Федерации, указанного в абзаце втором настоящей статьи, производятся Российской Стороной в соответствии с законодательством Монголии.

### Статья 5

Положения настоящего Соглашения могут быть изменены и дополнены по согласованию Сторон в письменной форме.

### Статья 6

Разногласия Сторон относительно применения и толкования положений настоящего Соглашения решаются Сторонами по дипломатическим каналам.

### Статья 7

Настоящее Соглашение вступает в силу с даты получения последнего письменного уведомления о выполнении Сторонами внутригосударственных процедур, необходимых для его вступления в силу.

### Статья 8

Монгольская Сторона осуществит переоформление прав на Российскую Федерацию на земельные участки, предусмотренных в статье 1 настоящего Соглашения и статье 1 Соглашения от 6 августа 1980 года, не позднее одного года с даты вступления в силу настоящего Соглашения при условии предоставления Российской Стороной комплекта необходимых документов.

### Статья 9

Действие настоящего Соглашения может быть прекращено только по взаимному письменному согласию Сторон. В таком случае действие настоящего Соглашения прекращается по истечении 180 дней с даты обмена между Сторонами дипломатическими нотами, подтверждающими такое согласие.

В случае прекращения действия настоящего Соглашения право пользования земельными участками и право собственности Российской Федерации на объекты недвижимости, перечень которых приведены в приложениях № 1 и 2 к настоящему Соглашению, а также право собственности Российской Федерации на новые здания и сооружения, указанные в статье 4 настоящего Соглашения, сохраняются в полном объеме до заключения нового соглашения.

Совершено в г. \_\_\_\_\_ «\_\_\_» \_\_\_\_\_ года  
в двух экземплярах, каждый на русском и монгольском языках, причем оба текста имеют одинаковую силу.

**За Правительство  
Российской Федерации**

**За Правительство  
Монголии**

Приложение № 1

к Соглашению между Правительством Российской Федерации и Правительством Монголии об условиях реоформления прав Российской Федерации на земельные участки и расположенные на них объекты недвижимости на территории Монголии

Перечень земельных участков и объектов недвижимости Российской Федерации, права на которые подлежат оформлению

№	№	№	Кадастровый номер земельного участка	Площадь земельного участка (гектаров)	Объект недвижимого имущества	Площадь общая объекта недвижимого имущества (кв. метров)	Этажность	Местоположение
1.	1	1	1330800940	2,3351	Службное здание	1557,00	2	г. Улан-Батор Баянзурхский район
	2	2			Торгово-офисное здание	542,20	1	
	3	3			Здание	386,10	1	
	4	4			Клуб	1243,30	1	
	5	5			Здание	1137,55	2	
	6	6			Жилый дом	3342,10	12	
	7	7			Жилый дом	701,20	2	
	8	8			Нежилое здание	28,00	1	
	9	9			Теплица	62,50	1	
	10	10			Склад	108,20	1	
2.	11	1	1330801043	0,8294	Здание	664,65	2	г. Улан-Батор Баянзурхский район
	12	2			Гараж-стоянка на 18 автомашин	559,47	1	
	13	3			Здание (Храм)	265,33	2	
	14	4			Здание спортзала	516,81	1	
	15	1			Жилый дом	3383,70	5	
3.	16	2	1330600455	0,5925	Клуб	422,30	1	г. Улан-Батор Баянзурхский район
	17	3			Гараж	235,70	1	
	18	1			Главный корпус	4224,70	4	
	19	2			Бассейн	1043,66	1	

4.	20	3	1330800933	2,0950	Корпус с переходом	3778,45	4	Баянзурхский район
	21	4			Ангар	238,37	1	
	22	5			Спортзал	817,75	1	
	23	6			Хозяйственный корпус	768,11	1	
	24	7			Детский сад	268,09	1	
	25	8			Дизельная станция	77,82	1	
	26	9			Проходная	48,80	1	
	27	1	1330700447	0,1080	Гараж	368,7	1	
	28	1			Квартира № 1	48,70	-	
	29	2			Квартира № 2	68,60	-	
	30	3			Квартира № 3	35,50	-	
	31	4			Квартира № 4	67,30	-	
	32	5			Квартира № 5	48,70	-	
	33	6			Квартира № 6	55,20	-	
	34	7			Квартира № 7	47,50	-	
	35	8			Квартира № 8	67,40	-	
	36	9			Квартира № 9	48,70	-	
	37	10			Квартира № 10	55,20	-	
	38	11			Квартира № 11	47,50	-	
	39	12			Квартира № 12	67,40	-	
	40	13			Квартира № 13	48,70	-	
	41	14			Квартира № 14	55,20	-	
	42	15			Квартира № 15	47,50	-	
	43	16			Квартира № 16	67,40	-	
	44	17			Квартира № 17	48,70	-	
	45	18			Квартира № 18	55,20	-	
	46	19			Квартира № 19	47,50	-	
	47	20			Квартира № 20	67,40	-	
	48	21			Квартира № 21	48,70	-	
	49	22			Квартира № 22	55,20	-	
	50	23			Квартира № 23	47,50	-	
	51	24			Квартира № 24	67,40	-	
	52	25			Квартира № 25	48,70	-	
	53	26			Квартира № 26	55,20	-	
5.					г. Улан-Багор			Баянзурхский район

6.

54	27
55	28
56	29
57	30
58	31
59	32
60	33
61	34
62	35
63	36
64	37
65	38
66	39
67	40
68	41
69	42
70	43
71	44
72	45
73	46
74	47
75	48
76	49
77	50
78	51
79	52
80	53
81	54
82	55
83	56

Квартира № 27	47,50	-
Квартира № 28	67,40	-
Квартира № 29	48,70	-
Квартира № 30	55,20	-
Квартира № 31	47,50	-
Квартира № 32	67,40	-
Квартира № 33	48,70	-
Квартира № 34	55,20	-
Квартира № 35	47,50	-
Квартира № 36	67,40	-
Квартира № 37	67,40	-
Квартира № 38	47,50	-
Квартира № 39	55,20	-
Квартира № 40	48,70	-
Квартира № 57	67,40	-
Квартира № 58	47,50	-
Квартира № 59	55,20	-
Квартира № 60	48,70	-
Квартира № 61	67,40	-
Квартира № 62	47,50	-
Квартира № 63	55,20	-
Квартира № 64	48,70	-
Квартира № 65	67,40	-
Квартира № 66	47,50	-
Квартира № 67	55,20	-
Квартира № 68	48,70	-
Квартира № 69	67,40	-
Квартира № 70	47,50	-
Квартира № 71	55,20	-
Квартира № 72	48,70	-

г. Улан-Батор


Район Баянгол

7.	84	1	1460100133	0,3497	Часть здания (помещения 1-го этажа, 3-го подъезда здания и гаражей, расположенных в здании под № 1 и № 2); Часть здания (помещения 2-го и 3-го этажа, 2-го подъезда здания и гаражей, расположенных в здании под № 3 и № 4)	1332,81	3	г. Улан-Батор	Район Сүхэ-Багор	Дорнод аймаг, Хэрлэн сомон					
											85	1	Административное здание	1155,10	2
											86	2	Жилое здание	524,60	2
8.	86	2	2106000587	1,4995	Административное здание	1155,10	2	г. Чойбалсан	Дорнод аймаг, Хэрлэн сомон						
										87	3	Бытовое здание	75,90	1	
										88	1	Служебное здание	2355,30	2	
9.	89	2	6103300268	1,7609	Жилое здание	778,08	3	Орхонский аймаг	Баян-Ундур сомон						
										90	3	Гараж и хозяйственный корпус	269,30	1	
										91	4	Бензоколонка	24,00	1	
	92	5			Здание почты и охраны	14,04	1								
	93	6			Внешнее ограждение	1365,90	-								

Приложение № 2  
к Соглашению между Правительством  
Российской Федерации и Правительством  
Монголии об условиях переоформления прав  
Российской Федерации на земельные  
участки и расположенные на них  
объекты недвижимости на территории  
Монголии

«Приложение  
к Соглашению между Правительством  
Союза Советских Социалистических  
Республик и Правительством  
Монгольской Народной Республики  
о выделении земельного участка для  
строительства здания представительств  
Аэрофлота, АПН и Совэкспортфильма  
в г. Улан-Баторе и об условиях  
строительства  
от 6 августа 1980 года  
(в редакции Соглашения между  
Правительством Российской  
Федерации и Правительством  
Монголии об условиях  
переоформления прав Российской  
Федерации на земельные участки и  
расположенные на них объекты  
недвижимости на территории  
Монголии)

Схема размещения земельного участка



Номер единичной площади земельного участка: 1460100133

Адрес: г. Улан-Батор, район Сухэбатор, улица Сеула, 4-й участок. Кадастровая область: 100»

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ЭДЭЛБЭР ГАЗАР БОЛОН ТЭДГЭЭРТ БАЙРЛАХ  
 ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ОБЪЕКТУУДЫН ЭРХИЙГ ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН  
 НЭР ДЭЭР ШИНЭЧЛЭН БҮРТГЭХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
 ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН  
 ХЭЛЭЛЦЭЭРИЙН АСУУДЛААРХ АЖЛЫН ХЭСЭГ**

Д/д	Нэр	Албан тушаал	Утас
1.	Б.Цэнгэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга	99114512 261692
2.	Д.Нарангэрэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга	99069881 263021
3.	Ж.Соёлмаа	Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал	99997020 261378
4.	Д.Бат-Өлзий	Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал	99195050 261378
5.	Ц.Буянтогтох	Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын атташе	88832108 261378
6.	З.Энхболд	Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга	96652191
7.	А.Энх-Эрдэнэ	Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга	91915162
8.	Д.Болормаа	УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга	88109933
9.	Ө.Өнөрлхам	УБЕГ-ын улсын ахлах бүртгэгч	99160889
10.	О.Одбаяр	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	99190769
11.	Б.Бумням	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Хот байгуулалтын кадастрын систем хариуцсан ахлах мэргэжилтэн	99035003
12.	Т.Даваадалай	Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч	88109260

13.	М.Үнэнбат	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга	99089454
14.	Г.Мөнхбаатар	Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга	99053872
15.	В.Оюумаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга	99112924